

**МОНГОЛЬСКАЯ  
АКАДЕМИЯ НАУК**  
Институт истории и  
археологии

**МЕЖДУНАРОДНАЯ  
АССОЦИАЦИЯ  
МОНГОЛОВЕДОВ**

**РОССИЙСКАЯ  
АКАДЕМИЯ НАУК**  
Институт восточных  
рукописей



# **КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: КОЛЛЕКЦИИ РУКОПИСЕЙ И АРХИВНЫХ ДОКУМЕНТОВ**

III

**Международная конференция  
при поддержке Президента Монголии**



20-22 апреля 2017 г. Санкт-Петербург

Сборник докладов

Санкт-Петербург - Улан-Батор  
2019

ННА-72  
ДАА-378.121  
М-694

**Ответственный редактор:**  
**Редакторы, составители:**

Академик С.Чулуун  
доктор филол.наук И.В.Кульганек

Ph.D Н.Хишигт

Ph.D Б.Нацагдорж

Ph.D Н.В.Ямпольская

Ph.D Н.Ганбат

доктор филол.наук Л.Г.Скородумова

**Рецензенты:**

**Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов.** Сборник докладов III международной научной конференции. 20-22 апреля 2017 г. Санкт-Петербург. Россия. СПб.-УБ., 2019 г. -254 с.

Сборник представляет собой собрание докладов III международной научной конференции **"Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов"**, организованной Институтом истории и археологии МАН и Институтом восточных рукописей РАН в г.Санкт-Петербург, 20-22 апреля 2017 г.

Основой для конференции стали рукописные фонды и архивы, хранящие документы и материалы по истории, культуре, этнографии, политике, языку монгольских народов.

В сборнике публикуются доклады, освещающие историю монголоведения, а также доклады, посвященные рукописным материалам о материальной культуре монголов, их письменному наследию, художественному творчеству, экспедициям и разным сторонам жизни традиционного и современного монгольского общества.

ISBN 978-99978-773-4-5

DOI 10.25882/76vd-bb41

© Институт истории и археологии МАН, 2019 г.

© Институт восточных рукописей РАН, 2019 г.

© Международная Ассоциация монголоведов, 2019 г.

С. Чулүүн

## КРАКОВЫН АРХИВ ДАХЬ «ТОД» ҮСГИЙН ЗАХИДЛЫН ТУХАЙ

DOI 10.25882/48w0-x064

### **1. Оршил**

Монголын түүхийн судалгааны чухал сурвалж, архивын баримтууд илэрч олдсоор байна. Монголын түүхийн судалгааны дотор нэгэн чухал үе бол XVII зууны үе мөн. Энэ үеийн түүхийн судалгаа өнөөг хүртэл зөвхөн хэдхэн сурвалж бичигт тулгуурлан судлагдаж байсан юм. Харин сүүлийн хэдэн жил Монгол улс, Өвөр Монгол зэрэгт олон сурвалж, архивын баримтуудыг хэвлэн нийтэлсэн билээ.

Харин ОХУ бол энэ үеийн түүхийг судлах нэгэн чухал газар болно. Ялангуяа Москва хот дахь Эртний улсын Архив (РГАДА) чухал үүрэгтэй. Миний бие РГАДА-гаас XVII зууны Монголын түүхийг судлах олон шинэ эх сурвалжийг олж судалгааны эргэлтэд оруулсан. Тэдгээр сурвалжууд нь Орос хэлнээс гадна монгол, тод үсгийн захидалууд байлаа. Нийтдээ 30 орчим шинэ захидал эх хэрэглэгдэхүүн илэрсэн билээ.

Харин энэ материалаас дутахааргүй чухал баримтууд Польш улсын Krakow хот дахь Польшийн Урлагийн Академийн архивт хадгалагдаж байна. Тус архивт нэрт монголч эрдэмтэн Л.В.Котвичийн цуглуулга дотор байгаа юм. Тус архивт хадгалагдаж буй XVII зууны эх материалыг судлан шинжлэх боломжийг Варшавын Их сургуулийн доктор, Монгол судлаач Agata-Vарженский надад олгосон юм. Түүний дэмжлэгээр дээрх захидалуудыг хувилан авч судлах зөвшөөрлийг албан ёсоор авсан билээ. Тиймээс энэ удаагийн хуралд тус архивт хадгалагдаж байгаа XVII зууны түүхэнд хамаарах «тод» үсгийн захидалуудыг танилцуулахыг зорьсон юм.

### **2. Тод үсгийн захидалуудыг танилцуулахыг зорьсон юм**

Тус архивт хадгалагдаж байгаа захидалууд нь нийтдээ 17 тод үсгийн захидал баримт байна. Эдгээрээс гадна 1 ширхэг орос үсгээр бичсэн монгол захидалын хэсэг буй. Захидалуудын хэмжээ янз бүр бөгөөд 9-52 см хүртэл өргөнтэй, 16.5-36 см хүртэл өндөртэй захидалууд байна. Орос цаас дээр бичигдсэн. Тэдгээрээс 4 захидал ямар нэгэн тэмдэг

үсэгтэй тамгатай. Харин 1 захидал Галдан Бошигтын дөрвөлжин үсгийн тамгатай. Энэ захидалын тамга нь РГАДА-д хадгалагдаж байгаа 1691 оны үеийн Ачин багшаар илгээсэн нэгэн захидалтай адил тамгатай байна.

Захидлуудын бичсэн байдал зарим нь албаны нягт нямбай бичвэртэй, зарим нь маш болхи бичигтэй байна. 6 захидал урагдаж гэмтсэн. Уншихад нэлээд төвөгтэй байна. Харин тамгатай захидалууд ямар нэгэн саад бэрхшээл алга.

Эдгээр захидалууд Л.В.Котвичийн архивт хадгалагдах болсон шалтгааныг нэлээд анхаарч үзсэн. Л.В.Котвич 1919 онд «Известия Российской Академии наук» bulletin сэтгүүлийн 12-15 дугаарт «*Русские архивные документы по сношениям с ойратами в XVII и XVIII веках*» цуврал өгүүлэлийг нийтлүүлсэн. Өгүүллийн оршилд XVII-XVIII зууны ойрадын түүхийн судалгаа ихээхэн харанхуй байгааг дурдаад Орос, Европ, Хятад зэрэгт ойрадын энэ үеийн түүхийг судлах эх сурвалжуудын тоймыг нэлээд нарийн гаргасан байна.

Л.В.Котвич, эдгээр захидалуудыг санамсаргүй байдлаар хувь хүнээс нэлээд хэдэн жилийн өмнө олж авсан гэж бичсэн байна<sup>85</sup>. Нийт захидалууд бүгд XVII зууны төгстөл үеийнх гэж тэмдэглэжээ. Мөн уг захидалуудыг Тобольскийн архивт байсан болов уу хэмээн тэмдэглэжээ. Гэхдээ эдгээр захидалыг огт уншиж тайлбар хийгээгүй юм. Өөрөөр хэлбэл эдгээр захидал өнөөдрийг болтол судалгааны эргэлтэд ороогүй байна гэсэн үг. Уг захидалууд түүнийг 1920-иод онд Польшид Ленинград хотоос шилжин очиход түүний авч явсан материал дотор байжээ. Тод үсгийн эдгээр захидалыг нарийвчлан судлах, он цаг, бичигдсэн газар нутаг, илгээсэн эздийг тодруулах ажил эдүгээ хийгдэж байна. Гэвч зарим захидалд тодруулах мэдээ баримт маш бага бөгөөд бусад орос хэлний баримтуудыг түшиглэх, эсвэл тодорхой үйл явцтай холбооос өөр аргагүй зүйлс ч нэлээд байна.

### **Тод үсгийн захидалын агуулга**

Краковын архивт хадгалагдаж байгаа эдгээр захидалуудын агуулга, түүний байдлыг товч өгүүлбэл дараах байдалтай байна. Их төлөв захидалууд нь Галдан бошигт, түүний элч нартай холбоотой болох нь

<sup>85</sup> стр. 821.

мэдэгдэж байна. Мөн Оросын Сибирийн хотууд Томск, Тобольской харилцсан хэргүүд, мөн худалдааны хэргийг тодорхой тэмдэглэжээ. Зарим захидалд Урианхай буюу үслэг эдлэлийн албан төлдөг Тува нарын хэргийн талаар нэлээд бичсэн байна. Энэ нь урианхай нар Орост татвар төлөх болсонтой холбоотой баримтууд байна. Урианхай нараас авдаг албаны хэмжээ, албанд авдаг эд зүйлсийн нэрс ч үзэгдэнэ.

Тэд 1670-аад оны үе хүртэл Хотогойдын Алтан хаан, 1680-аад он хүртэл Ойрадуудад үслэг эдлэлийн татвар төлдөг байснаа 1690-ээд оноос Монголчуудад давхар татвар төлөхөө больсон юм. Тиймээс нэлээд маргаан өрнөсөн байдаг. Тэр тухай зарим захидалд өгүүлжээ.

Тухайлбал:

*"idbala tübšin jaisang-du ögbö. Usuni urāngxayin alba čamlaya abxiyin tustu, urāngxayin axalayčidu üjüülkü bičig ögbö. Modun nohoyn 1 sara-yin dolon ödür"*

«Идбала Түвшин зайсанд өгөв. Усны Урианхайн алба чамлага (tax) авахын туст, урианхайн ахлагчид үзүүлэх бичиг өгөв. Модон нохой 1 сарын 7 ны өдөр»

Нохой жил 1670, 1682, 1694 онуудад таарч байна. Эдгээрээс 1670 он бол боломжгүй. Энэ үед Ойрадыг Сэнгэ захирч байсан бөгөөд Урианхай нараас татвар авч эхлээгүй байсан. Мөн 1694 оны нохой жил гэж үзвэл энэ Галдан бошигтоос бус Цэвээнравдангаас илгээсэн байх магадлалтай. Тэр үед Галдан бошигт Чин улстай дайн хийж Бээжингийн ойролцоо Улаан буданд байсан. Харин Галдан бошигттой холбоотой гэж үзвэл 1682 оны нохой жил болно. Энэ үед Галдангийн цэрэг Тагна-Тува, Хөвсгөлийн баруун биед орж ирсэн байсан юм. Тэгэхээр он цагийг бид 1682 оны нохой жил байж магадгүй гэж үзэж байна. Ийм байдлаар дээрх захидалуудыг агуулга, түүхэн үйл явдлаар нь хөөж он цагийг тогтоох боломж бага зэрэг байгаа юм.

Мөн зарим захидалын агуулгад Халх буюу долоон хошууны монголчуудтай дайтсан тухай мэдээ нэлээд байна. Энэ нь 1686 оны Түшээт хаан Чахундоржийн цэрэгтэй дайтсан эсвэл 1696 оны Зуун модны тулаан байж болно. Гэхдээ 1696 оны тулааны дараа Галдангаас Оросын хаанд захидал бичих боломж бараг гараагүй юм. Тэгэхээр

уг захидалууд нь 1686-1690 оны орчмынх болох нь мэдэгдэж байна. Захидалд «*bida mordoji dolōn xošiin xalxīgi abād*» «долоон хошуу Халхыг аваад....» хэмээн бичсэн нь Халхад ойрадууд орж ирсэн тухай мэдээ байна. Худалдааны хэргийн тухай хэд хэдэн захидал байна. Томскийн захирагчид бичсэн захидалд Их цагаан хаантай хийсэн худалдаанд замд ихээхэн саад болж байгаа тухай өгүүлээд Их цагаан хаантай эвтэй найртай байхыгаа өгүүлсэн Галдан бошигтын захидал байна. Галдан бошигтын захидалд буй энэхүү тамга нь РГАДА-д буй захидалын тамгатай ижил бөгөөд захидалын хэв маяг жаахан ялгаатай. 1691 оны түүний захидал нь тусгайлан бэлтгэсэн цаас дээр тойруулан хээ угалз зурж ихэд хүндэтгэл үзүүлсэн байдал харагддаг.

Галдан бошигт болон Ойрадын ноёдоос илгээсэн дээрх захидалууд нь агуулгын хувьд худалдаа, алба татвар, эзэн харьяат, халх, ойрадын харилцаа, орос, ойрадын харилцааны онцлог зэргийг тусгасан ихээхэн сонирхолтой захидалууд байна. Ерөнхийдөө захидалуудыг дотор нь алба татвар, худалдаа, улс төрийн харилцаа гэсэн хэдэн хэсэгт хувааж үзэж болохоор байна.

Мөн эдгээр захидалуудын агуулгыг тодруулах зүйл нь тухайн үед ойрадаас Орост очсон элч нарын мэдүүлэг зэрэгтэй харьцуулан үзэж болно. Харин зарим орон нутгийн шинжтэй захидалууд нь тодруулах боломж нэлээд бага байна.

### **Тод үсгийн захидалын түүхэн ач холбогдол**

Тод үсгийн түүхэн сурвалж, архивын баримтын түүхийн судалгааны ач холбогдлын тухай өнөөдөр дэлхийн монголч эрдэмтдийн бүтээлд нэлээд чухалчилсан байна. Харин миний өгүүлж буй эдгээр тод үсгийн захидал нь хэд хэдэн чухал талтай. Юуны өмнө XVII зууны Ойрад, Оросын харилцаанд хамаарах тод болон монгол үсгийн захидал маш ховор юм. Эдгээр захидалуудын нэг давуу тал нь үндсэн эх болно. Сүүлийн үед Бээжинд хэвлэж байгаа тод, монгол үсгийн захидал бичгүүд нь ихэвчлэн хуулбар эх болно. Манжийн Гадаад Монголыг захирах яамны газраас монголчуудаас өгсөн захидалыг хуулбарлан манж монгол хэлээр буулган хаанд мэдүүлж байсан. Харин Польш, Оросын архивуудаас олдож буй эдгээр захидал нь жинэхэнэ эх (*подлинник*) юм. Польшийн Krakow хотын архиваас олдсон эдгээр захидалууд нь Монголын XVII зууны түүхийн чухал мэдээллээс гадна тухайн үеийн Орос, Монголын харилцааны улс

төрийн харилцаанаас гадна харьятын асуудал, худалдаа, нүүдэл, зөрчлийн асуудлыг тодруулах чухал мэдээлэл байна. Тухайн захидлуудын он цаг, бичсэн эзэн зэргийг бүрэн тодруулж чадвал цогц судалгаа болно. Мөн зарим тооны захидлууд дээрх тамга тэмдэг зэргийг тайлж унших асуудал бас чухал юм. Мөн орос хэл дээр буй олон баримтуудыг тодруулах, нэр томъёог зөв тайлбарлахад энэ захидлууд ихээхэн ач холбогдолтой болно.

Тод үсгийн эдгээр захидлын түүхийн судалгаанд оруулснаар XVII зууны үеийн Монголын баруун хэсэг ойрадуудын түүхийг тодруулахаас гадна тухайн үеийн захидал, албан бичиг үсгийн хөгжлийн хандлагыг тодруулж судлах боломжийг бас олгоно.

### **Дүгнэлт**

Ийнхүү эцэст нь тэмдэглэхэд Польш улсын Krakow хот дахь Польшийн Урлагийн Шинжлэх Ухааны Академийн архив дахь Л.В.Котвичийн цуглуулга дахь XVII зууны ойрадын түүхэнд холбогдох захидлууд нь Монголын түүхийн судалгааны эргэлтэд анх удаагаа орж байгаа бөгөөд цаашид бид нарийвчлан судлаж байна. Тухайн үеийн Монголын ойрадуудын түүхийг судлах, тэдний гадаад харилцаа, худалдаа, аж ахуй, улс төрийн ойлголт зэргийг судлахад ихээхэн чухал баримт болно. Монголын түүхийн судалгааны нэгэн чухал үеийн эх баримт Польшийн архиваас олдсон нь чухал бөгөөд түүнийг Оросын болон Бээжингийн орос, манж хэлний материалуудтай харьцуулан судлах боломжийг олгож байна.

Мөн тухайн үеийн Орос-Ойрадын харилцааны онцлог, тэдний эрх ашиг, ноёдын байр суурийг тодруулахад дээрх захидлууд ихээхэн үүрэг гүйцэтгэх бөгөөд судалгааны хувьд улам өргөн хүрээг хамрах болно. Тус захидлууд нь эх баримтаараа үлдэж хоцорсон бөгөөд цаашид бид эхээр нь болон галиг, тайлбарын хамт хэвлэн нийтлэхээр ажиллаж байна.